

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
МОНГОЛ УЛСАД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН 2024 ОНЫ ТАЙЛАН**

2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Сайншанд хот

Д/ д	Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
Хүний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, эд хөрөнгө халдашгүй байх эрхийг хангах талаар			
1	Хүний хувийн нууцтай холбоотой ажил үйлчилгээ эрхэлдэг бүх хэвшлийн байгууллагуудын ажилтнуудад сургалт явуулах, амлалт авахуулах зэргээр хариуцлагыг дээшлүүлнэ.	Албан хаагч нарт сургалт зохион байгуулах, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Бүртгэлийн үйл ажиллагаанд хувь хүний нууцыг чандлан хадгалах, иргэний бүртгэлийг иргэн зөвхөн өөрөө хүсэлт гаргасны үндсэн дээр хийх, хүсэлт гаргасан иргэний зөвхөн хурууны хээгээр бүртгэлийн үйлчилгээг явуулж хэвшээд байна. Мэдээлэл технологийн ажилтан сар бүр улсын бүртгэгч нараас нууцын баталгаа гаргуулж бүртгэгч нарын компьютер болон программын нэвтрэх нууц үгийг сольдог. Мөн сонгуулийн үйл ажиллагаатай холбоотойгоор сонгуулийн Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнууд аймгийн Тагнуулын хэлтэст нууцын баталгаа гаргасан.
Төрийн жинхэнэ (захиргааны болон тусгай) алба хаших эрхийг хангах талаар			
2	Төрийн захиргааны болон тусгай алба хаших нөхцөл болзол нь нийт иргэний хувьд адил тэгш байх үндсэн дээр төрийн албанд иргэдийг шалгаруулж авах, мэргэшүүлэн ажиллуулахдаа намчирхах, нутгархах, танил талаар дэмжих, улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлах, авилгалд автах зэрэг хууль бус үйлдэлд өртөхгүй, тийм хандлага гаргахгүй байх баталгаа бий болгоно.	Сул орон тоонд албан хаагч нарыг сонгон шалгаруулж авах	Тайлант хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн 1, иргэний улсын бүртгэгчийн 2 орон тоонд хүсэлт гаргасан иргэдийн материалыг УБЕГ-ын хүний нөөцийн газарт хүргүүлж Төрийн албаны тусгай сонгон шалгаруулалт зарласны үндсэн дээр Т.Булгамаа, Б.Мөнх-Учрал, Б.Номин-Эрдэнэ нар шалгалтанд тэнцэж томилогдон ажиллаж байна.

Өмчлөх эрхийг хангах талаар

3	<p>Монгол улсын иргэдэд газар хувьчлах, үл хөдлөх хөрөнгийн эрхийн бүртгэлийг боловсронгуй болгох, иргэдийн өмчлөх эрхийг улам бэхжүүлж, баталгаажуулна.</p>	<p>Эрхийн бүртгэлийн талаар үзүүлсэн үйлчилгээ</p>	<p>Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийг хууль тогтоомжийн дагуу бүртгэж баталгаажуулах, бүртгэлийн чанар, хяналтыг дээшлүүлэх зорилготой ажиллалаа.</p> <p>Хагас жилийн байдлаар хэлтсийн хэмжээнд эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхээ бүртгүүлэхээр иргэн, хуулийн этгээдээс 8078 мэдүүлгийг хүлээн авсан. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> - Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 425 - Шинээр баригдсан орон сууц анх удаа бүртгүүлэх-105 - Төрөөс үнэгүй хувьчилсан орон сууцны өмчлөх эрх баталгаажуулалт -16 - Төрөөс үнэгүй хувьчилсан газар өмчлөх эрхийн анхны бүртгэл -518
---	--	--	--

Бусад чиглэлээр

4	<p>Гүйцэтгэх эрх мэдлийн болон аж ахуй нэгж, байгууллагын захиргаанаас хүмүүсийн үйл ажиллагаанд чирэгдэл учруулдаг зөвшөөрлийн илүүц журам тогтоох, хясан боогдуулж авлига авах аливаа арга хэлбэртэй тууштай тэмцэнэ.</p>	<p>Улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй болгох чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх</p> <p>Улсын бүртгэлийн үйлчилгээг зөврийн тоног төхөөрөмжөөр хүргэх</p>	<p>“Дугаар дуудагч киоск” машин, төлбөр төлөгч киоск машинуудаар үйлчилснээр иргэдэд ил тод нээлттэй, хүртээмжтэй шуурхай үйлчлэх боломж бүрдсэн.</p> <p>Тус хэлтэс нь улсын бүртгэлийн зөврийн тоног төхөөрөмжөөр тайлант хугацаанд дараах бүртгэлийн үйлчилгээг очиж үзүүлсэн байна. Үүнд:</p> <p>-Дорноговь аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар ял эдэлж байгаа 7 иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл, 2 иргэний гэрлэсний бүртгэл, хөгжлийн бэрхшээлтэй 3 иргэний биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэл, овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний 1 бүртгэл хөтөлсөн.</p> <p>-Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн 30 албан хаагч, Хаан банкны 50 албан хаагч, Дорноговь аймаг дахь Шүүхийн 23 албан хаагчдад тус тус тоон гарын үсэг олгосон.</p>
---	---	--	--

			<p>- “Шинэ хоршоо” хөдөлгөөн улс даяар хэрэгжсэнтэй холбоотой тус хэлтсийн 14 сумдын бүртгэгч нар малчдад хуулийн этгээдийн бүртгэлийн талаар мэдээлэл өгч шинээр нийт 160 хоршоог үүсгэн байгуулж мэдээлэлд өөрчлөлт оруулсан.</p> <p>Замын-Үүд сумын ачаа тээврийн компанийн жолооч, Хилийн цэргийн 0108 дугаар ангийн албан хаагч, УБТЗ-ын Замын-Үүд татах хэсгийн ажилтнууд, Замын-Үүд дахь Гаалийн газар гэх мэт албан хаагч нарт хил орчмын нутгаар зорчих үнэмлэх 10373, гадаад пасспорт 2888 ширхэгийг, тоон гарын үсэг 414 олгосон.</p>
5	<p>Бүх шатанд авлигыг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.</p>	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хангаж ажиллах</p>	<p>Замын-Үүд сумын улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд тав тухтай болгох зорилгоор хэлтсийн даргын хүсэлтийг үндэслэн Замын-Үүд сумын Засаг дарга Б.Анхбаяр нэг дор олон хүн хүлээн авах боломжтой зай талбай бүхий үйлчилгээний танхимыг шинээр тохижуулан үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Улсын бүртгэлийн байгууллагын Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан 16 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг хэлэлцүүлэн баталж, хэрэгжилтийг хангуулан ажилласан.</p> <p>Хэлтсийн ахлах нягтлан бодогч-1, төрийн захиргааны 23 албан хаагчийн ХАСХОМ-ын мэдүүлгийг цаасаар болон цахимаар хүргүүлэн ажилласан. Тайлант хугацаанд шинээр томилогдсон 3 албан хаагчийн ХАСХОМ-ийн мэдүүлгийг хүргүүлсэн.</p> <p>Хэлтсийн албан хаагчидтай холбоотой авлигын хэрэг зөрчил гараагүй, иргэн, хуулийн этгээдээс үүнтэй холбоотой санал, гомдол ирүүлээгүй байна.</p> <p>Авилгатай тэмцэх газраас бэлтгэсэн “Авлигын эсрэг нэгдэвт шторкинфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг зэргийг тус хэлтсийн үйлчилгээний танхимд дэлгэцээр тогтмол явуулан иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна мөн Соёмбо цогцолборын үүдэнд, үйлчилгээний заалны хананд Авилгын эсрэг НЭГДЬЕ гэсэн шторк хуудсыг мэдээллийн самбарт байршуулж иргэд олон нийтэд хүргэн ажиллалаа. Хяналтын улсын байцаагч, бичиг хэргийн ажилтны өрөөний үүдэнд болон архивын өрөөний гадна хаалганд “АВИЛГА АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ХАМТ ОЛОН” гэсэн сурталчилгааны хуудсыг наан байршуулсан. Хэлтсийн албан хаагчдын авилга хээл хахууль, хүнд сурталын талаар мэдээлэл хүлээн авах 7052-2200 дугаарыг байршуулсан.</p>

6	<p>Засаг төрийн байгууллагаас хүний эрхийг хангах талаар явуулж буй үйл ажиллагаанд хяналт тавьж, ил тод болгоход олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг, бие даасан оролцоо нөлөөллийг идэвхижүүлэх арга хэмжээ авна</p>	<p>Улсын бүртгэлийн үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомжийн хэрэгжилт бусад цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэд, олон нийтэд цаг тухайд нь хүргэж, сурталчилан тус газрын удирдлага, албан тушаалтнуудыг нэвтрүүлэг, ярилцлагад оролцуулах арга хэмжээ авах</p>	<p>Хэлтсийн дарга Ц.Тэгшжаргал нь Дорноговь аймгийн DSB телевизд Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн талаар болон Улсын бүртгэлийн хэлтээс хийж буй онцлог ажлууд, цаг үеийн мэдээ мэдээллийг хийж олон нийтэд сурталчилсан.</p> <p>УБЕГ-ын даргын 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 3/10321 дугаартай “Чиглэл хүргүүлэх” тухай албан бичгийн дагуу Улсын бүртгэлийн үйлчилгээг зөвхөн хурууны хээгээр явуулах болсон талаар иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга Б.Баттуяа агентлагийн дарга нар болон иргэдэд Эд хөрөнгийн эрхийн улсын тасгийн дарга Г.Батсайхан Монгол банк болон арилжааны банкны дарга нарт мэдээлэл өгч ажилласан.</p> <p>Хуулиар тогтоосон хугацаатай бүртгэлийг хийлгэхэд анхаарах асуудал, бүрдүүлэх материалыг давхар сурталчилж төрсний бүртгэл, 16 насанд хүрч шинээр иргэний үнэмлэх авах, 25, 45 насанд хүрч иргэний үнэмлэхний сунгалтын бүртгэл хийлгэхтэй холбоотой 3 контент бэлтгэн цахимд байршуулж сурталчилсан.</p>
7	<p>Хүний эрхийн тухай ойлголт болон хүний эрхийн талаар эрх зүйн боловсрол олгох сургалт зохион байгуулах, байгууллагын ажилтнуудыг хамруулах</p>	<p>3.1. Нийт албан хаагчдын хүний эрхийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сургалт зохион байгуулах</p>	<p>Хүний эрхийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор тус аймаг дахь Хүний эрхийн үндэсний комиссын орон нутаг дахь төлөөлөгч Н.Мөнгөнчулуун 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр “Төрийн үйлчилгээнд хүний эрхийн мэдрэмжтэй хандах нь” сэдэвт сургалтыг хэлтсийн нийт албан хаагчдад зохион байгуулсан.</p>

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

УЛСЫН БҮРТГЭГЧ

ТАЙЛАН ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА

Г.НАНДИН-ЭРДЭНЭ

Ц.ТЭГШЖАРГАЛ

